


МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2017 оны 03 сарын 31 өдөр

Дугаар А/124

Улаанбаатар хот

Г
Мэргэжлийн багийн бүрэлдэхүүн,
ажиллах журам, тархины үхлийн
эмнэлзүйн шалгуур батлах тухай

Монгол Улсын Донорын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2, 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


- Тархины үхэл тодорхойлох багийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг нэгдүгээр, Тархины үхлийн эмнэлзүйн шалгуурыг хоёрдугаар, Тархины үхлийг шинжлэн бүртгэх картыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.
- Журмыг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Эмнэлгийн тусlamжийн газар /Я.Буянжаргал/, Улсын нэгдүгээр төв эмнэлэг /Б.Бямбадорж/-т үүрэг болгосугай.
- Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Д.Очирбат/-д даалгасугай.

САЙД



А.ЦОГЦЭЦЭГ

080402



Тархины үхэл тодорхойлох багийн бүрэлдэхүүн, ажиллах журам

Нэг. Нийтлэг зүйл

1.1. Тархины үхэл тодорхойлох баг /цаашид баг гэх/-ийг амьгүй донор байрлаж буй эмнэлэг, төвүүд дээр эмнэлэг, төвийн даргын тушаалаар байгуулна.

1.2. Тухайн эмнэлэг/төвийн Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга нь тархины үхэл тодорхойлох багийн ахлагч байх бөгөөд эрчимт эмчилгээний тасаг болон мэдрэлийн тасгийн жижүүрийн мэдээг сонсож, тархинд цус харvasан болон тархины гэмтэлтэй байгаа боломжит донорын талаар мэдээлэл авч байна.

1.3. Тархины үхэл тодорхойлох багийн гишүүн нь тухайн мэргэжлээрээ 15-аас дээш жил тасралтгүй ажилласан, тэргүүлэх зэрэгтэй (Зөвлөх эмч, тасгийн эрхлэгч), эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээний зөрчил гаргаагүй мэргэжилтэн байна.

1.4. Тархины үхэл тодорхойлох багийн гишүүн ажил үүргээ гүйцэтгэх боломжгүй үед тус гишүүний ажлыг мэргэжлээрээ 10-аас дээш жил ажилласан туршлага бүхий эмч орлон гүйцэтгэж тархины үхэл тодорхойлох комисст орж ажиллана.

Хоёр. Багийн бүрэлдэхүүн

2.1. Тархины үхэл тодорхойлох баг нь дараах бүрэлдэхүүнтэй байна.

2.1.1. Багийн ахлагч: Тухайн донор байрлаж буй эмнэлэг/төвийн Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга

2.1.2. Багийн гишүүд:

- Эрчимт эмчилгээний эмч
- Мэдрэлийн эмч
- Мэдрэлийн мэс заслын эмч
- Донорын эмчлэгч эмч
- Чих, хамар, хоолойн эмч /шаардлагатай тохиолдолд/
- Дүрс оношилгооны эмч /шаардлагатай тохиолдолд/
- Эмгэг судлаач эмч /шаардлагатай тохиолдолд/
- Чанарын менежер

Гурав. Багийн ажиллах журам

3.1. Баг нь донорын эрүүл мэндийн байдал, холбогдох шинжилгээнүүд, тархины үхлийн эмнэлзүйн шалгуур, стандартыг баримтлан тархины үхэлтэй эсэхийг тодорхойлно.

3.2. Баг нь хуралдаж протокол хөтөлж гарын үсэг зурж баталгаажуулна.

3.3. Багийн ахлагч нь эмнэлэг/төвд байгаа боломжит донорын тухай мэдээлэл авсан даруйд багийн хурлыг зарлан хуралдуулж, боломжит донорыг хамтран үзэж стандартын дагуу тархины үхэл тодорхойлох маягтыг асуултын дагуу хөтөлж, протокол үйлдэж, гарын үсэг зурж баталгаажуулна.

3.4. Тархины үхэл эхэлсэн гэж үзэх цаг хугацааг тодорхой зааж тусгана.

3.5. Тархины үхэл тодорхойлох сорилын цээртэй заалтуудаас илэрсэн тохиолдолд тайлбар бичиж комиссын гишүүд гарын үсэг зурж, баталгаажуулан цаашид хийх сорилыг зогсооно.

3.6. Хийгдэх сорилуудыг мэргэжил, мэргэшлийн дагуу багийн гишүүд хийж гүйцэтгэн, тэмдэглэл хөтлөж протоколд тусгана.

3.7. Бичгээр тайлбар хийх шаардлагатай хэсгүүдийг нэмэлт хуудсанд гараар бичиж багийн гишүүд гарын үсэг зурж баталгаажуулна.

3.8. Заавал хийж гүйцэтгэх сорилуудын үр дүн эргэлзээтэй, хийх боломжгүй тохиолдолд стандартын нэмэлт шалгууруудыг хийж гүйцэтгэнэ.

3.9. Тархины үхэл нь тогтоогдоноос хойш 6 цагийн дараа давтан үзэж онош дахин батлагдсан тохиолдолд эрчимт эмчилгээний эмч, эмчлэгч эмчийн хамт боломжит донорын ар гэрийнхэнтэй уулзаж бодит байдлыг танилцуулна.

3.10. Багийн гишүүд тархины үхэл тодорхойлогдсон боломжит донорын талаар нэн даруй зохицуулагчид мэдэгдэнэ.

3.11. Амьгүй донорын талаарх шинжилгээ, мэдээллийг холбогдох эмнэлгээс гаргуулна.

3.12. Донорын эрүүл мэндийн байдал нь эрхтэн шилжүүлэн суулгахад харшлахаар бол донор болохыг хориглосон дүгнэлт гаргана.

ооОоо



Тархины үхлийн эмнэл зүйн шалгуур

1. Тархины үхлийг дараах шалгуураар тодорхойлно.

1.1. Тархины үхлийг тархины үхэл тодорхойлох баг 6 цагийн зйтай 2 удаа үзлэг хийж тогтооно.

1.2. Тархины үхлийг тогтоох үзлэгийн өмнө удаан хугацаагаар ухаангуйдэх, амьсгал зогсох гадны шалтгаан байгаа эсэхийг эмчлэгч эмч нягтлан тогтоож, бололцоотой бол лабораторийн шинжилгээгээр нотолсон байна.

1.3. Амьсгал бүрэн зогссон хүмүүст 20-24 цаг зохиомол амьсгал хийхэд амьсгал сэргэх шинжгүй байвал тархины баганын рефлексийн сорилуудыг хийнэ.

1.4. Гадны шалтгаан ба эмийн аргаар халуун бууруулаагүй, нойрсуулах, тайвшуулах, булчин сүлруулах эмийн нөлөө, хордлого үгүйг тогтоосны дараа баганын үхлийг шалгах сорилуудыг анхааралтай хийж гүйцэтгэнэ.

1.5. Тархины баганын рефлексүүдийг дараах сорилуудаар шалгана.

1.5.1. Хүүхэн харааны сорил: Хүүхэн хараа нэгэн хэмжээнд хэвшиж, тод гэрэл тусгахад урвал /өргөсөж, нарийсаж/ гарч байгаа эсэх;

1.5.2. Эвэрлэгийн рефлекс: Нүдний эвэрлэгт ариун бөмбөлгөөр зөөлөн хүрэлцэхэд зовхи хөдлөх эсэх;

1.5.3. Тэнцвэр /вестибуляр/-нүдний рефлекс: Чихний гадна 2 сувагт хүйтэн ус 20 мл-ийг урсгаж хийхэд нүд хэлбийх, чичрэх хөдөлгөөн гарах эсэхийг шалгана. /Сорилыг чихний хэнгэргийн бүтэн эсэхийг шалгасны дараа 2 чихэнд ээлжлэн хийнэ./

1.5.4. Нүд-тархины рефлекс: Толгойг хажуу тийш цочмог эргүүлэхэд нүдний харц толгойн хамт хөдлөх эсэх /хүүхэлдэйн нүд/; /Энэ сорилыг хүзүү гэмтсэн хүнд хийж болохгүй/

1.5.5. Залгиурын ба амьсгалын доод замын рефлекс: Ам, хамраар хаймсуур тавих, гуурсаар соруулах үед хөдөлж, ханиаж байгаа эсэх;

1.5.6. Хүчтэй өвтгөх цочролын хариу урвал: Нүдний ухархайн дээд ирмэг яс руу хүчтэй дараахад ямар нэг хариу урвал гарч байгаа эсэхийг шалгана. /Тархи үхсэн үед биеийн доод хэсэгт дарж цочрооход нугасны автоматизмаар хөдөлж болно/.

1.6. Тархины баганын рефлексийн сорилуудад ямар нэг цочролгүй бол амьсгал зогссоныг шалгах /апноэ/ сорил хийнэ.

1.7. Апноэ сорилыг дараах маягаар хийнэ. Үүнд:

1.7.1. Зохиомол амьсгалын аппаратаар 100 хувийн хүчилтөрөгчөөр 10-15 минут амьсгалуулна.

1.7.2. Дараа нь аппаратыг салгаж гуурсаар 1 минутад 4-5 л хүчилтөрөгч өгч ажиглана. Энэ сорилыг 10 минут хийхэд цусанд хүчилтөрөгчийн дутагдал болохгүй харин нүүрсхүчлийн хэмжээ /PaCO₂/ 60мм МУБ-аас илүү буюу амьсгалын төвийг хүчтэй цочроох хэмжээнд хүрэх бөгөөд энэ үед амьсгалах хөдөлгөөн огт үгүй байвал амьсгал эргэлтгүй зогсооны шинж гэж үзнэ.

1.8. Дээрх сорилуудыг хийхийн зэрэгцээ боломжтой үед тархи үхсэний /ялангуяа гадрын/ нэмэлт нотолгоо болгож тархины цахилгаан бичлэгийг /ЭЭГ/ 30 минутаас доошгүй хугацаагаар өдөрт 2-оос доошгүй удаа бичиж шалгаж болно.

1.9. Тархины үхлийг шинжилсэн тухай бүр тусгай картад тэмдэглэнэ.

1.10. Сэхээн амьдруулах арга хэмжээ үргэлжилж байгаа нөхцөлд эмч нарын комиссын дүгнэлтээр тархины үхэл болсон нь нотлогдсон тохиолдолд амьгүй донор гэж үзэж өөрийнх нь гэрээслэл, эсвэл ар гэрийн хүмүүсийн зөвшөөрлийг үндэслэн сэхээн амьдруулах ажиллагааг зогсоож эд, эрхтнийг шилжүүлэн суулгахаар авч болно.

ооОоо



ТАРХИНЫ ҮХЛИЙГ ШИНЖЛЭН БҮРТГЭХ КАРТ

Өвчтний	Овог:	Нэр:	Нас:	Хүйс:
Одоо эмчлэгдэж буй онош:				
Осол гэмтлийн шалтгаан:				
Одоогийн	өвчний		товч	түүх:

	I	II
Үзлэгийн дугаар		
Огноо		
Цаг		
Нэг. Гаднын буюу эмийн нөлөө		
1.1. Зориуд буюу гаднын шалтгаанаар халуун бууруулсан		
1.2. Нойруулах тайвшруулах эм хэрэглэсэн /сүүлийн 24 цагт/		
1.3. Өөрийн амьсгал байгаа		
1.4. Зохиомол амьсгалтай		
1.5. Биеийн одоогийн халуун		
1.6. Биеийн одоогийн артерийн даралт		
1.7. Биеийн одоогийн судасны лугшилт 1 минутанд		
1.8. Биеийн одоогийн захын судасны хүчилтөрөгчийн хэмжээ %		
1.9. Булчин супруулах эм хэрэглэсэн		
1.10. Вазопрессор эм хэрэглэж буй		
Хоёр. Хөдөлгөөн Бүх биеийн болон хэсэг газарт чичрэх, чангараах, татах хөдөлгөөн байгаа		
Гурав. Тархины баганын шинж		
1.1. Хүүхэн харааны голточ		
3.2. Хүүхэн харааны гэрлийн урвал		
3.3. Эвэрлэгийн урвал		
3.4. Хүчтэй өвтгөхөд хариулт		
3.5. Залгиур цагаан мөгөөрсөн хоолойн цочрох урвал		
3.6. Нүд-тархины рефлекс		

3.7 Чих-тархины рефлекс		
Дөрөв. Апноэ сорил / Ра СО2/-ыг үзсэн бол тэмдэглэх/		

Тайлбар:

- Картын огноо ба цагийг маш тодорхой бичиж хүснэгтэд "тийм", "илэрнэ", "үгүй", "эргэлзээтэй" гэх мэт тохирох хариултыг үгээр бичнэ.
- Карт хөтлөхийн зэрэгцээ өвчний түүхэнд протокол хөтөлнө.

Үзлэг хийсэн багийн бүрэлдэхүүн:

Албан тушаал _____ Нэр _____ Гарын үсэг _____

ооОоо